



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/190

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Онц байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болон гамшгийн онцгой үед аймаг орон нутгийн нийгэм, эдийн засаг, нийтийн хэв журам, гамшгаас хамгаалах мэргэжлийн алба, ангиудын тогтвортой үйл ажиллагааг хангах нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээний зардлын хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагаанд шаардагдах 12 000 000 /Арван хоёр сая/ төгрөгийг Онцгой тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Тусгагдсан зардлын дагуу зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Онцгой байдлын газар /н.Ганбаатар/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

02000 0937

Аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын
15-ны өдрийн 1/20 дугаар захирамжийн хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АЛБА, АНГИУДЫН НҮҮЛГЭН
ШИЛЖҮҮЛЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Үйл ажиллагааны зохион байгуулалт	Шаардагдах зардал /сая төгрөг/
1	Эрдэнэт хот, Орхон аймгийн дэд бүтэц, байр зүй, нууцын зэрэглэлтэй бичиг баримт ашиглах, нүүлгэн шилжүүлэлтийн нөөц өрөө, танхим, талбай, холбоожуулалтаар хангах	6.0
2	Техник тоног төхөөрөмж, цахилгаан, нөөц гэрэлтүүлэг, бусад инженерчиллийн шийдлүүдийг бэлэн болгох	3.0
3	Онцгой комиссын гишүүдийн аюугүй байдал, хөдөлмөр хамгаалал, ажиллагааны үеийн бэлэн байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх	3.0
	НИЙТ ДҮН	12,000,000